

## ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2016 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, нэгтгэлийг хүргүүлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийг Геологи, эрдэс баялгийн бодлого, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого, Уул уурхайн бодлого, Хүнд үйлдвэрийн бодлого, Нийтлэг асуудал гэсэн 5 ангиллаар хяналтад авсан 289 шийдвэрийн 416 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилт 86.2 хувийн биелэлттэй байна.

Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 23 шийдвэрийн 25 заалтын хэрэгжилт 94.0%, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 37 шийдвэрийн 44 заалтын хэрэгжилт 75.9%, уул уурхайн бодлогын асуудлын 50 шийдвэрийн 56 заалтын хэрэгжилт 78.0%, хүнд үйлдвэрийн бодлогын асуудлын 19 шийдвэрийн 30 заалтын хэрэгжилт 77.6%, нийтлэг асуудлын 160 шийдвэрийн 261 заалтын хэрэгжилт 88.4 хувийн тус тус биелэлттэй байна.

Мөн чиг үүрэг болон хариуцах асуудлын хувьд тус яаманд хамааралгүй болон бүрэн хэрэгжсэн 100 хувийн биелэлттэй зарим шийдвэрүүдийг тайлбарын хамт 2017 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр ЗГХЭГ-т цахимаар хүргүүлж, хяналтаас хасуулсан. Үүнд: МУ-ын хууль 5, УИХ-ын 3 тогтоолын 6 заалт, Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын 87 тогтоолын 39 заалт, Засгийн газрын хуралдааны 33 тэмдэглэлийн 34 заалт хамаарч байна.

Боловсруулсан: ХШҮДАГ-ын мэргэжилтэн

С.Цэцэг-Өлзий